



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар A/17

Жаргалант

Золбин нохой устгалд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төвийн золбин нохой устгалын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 24-нөөс 27-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Золбин нохой устгах иргэнтэй гэрээ байгуулан эрх олгох, зөвлөмжийг захиалагчид өгөх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Х.Баасансүрэн	Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга	Б.Баярмагнай	БО-ны мэргэжилтэн
Гишүүдэд	Э.Батдаваа	Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч
	Г.Оюунчимэг	Жаргалант багийн засаг дарга
	Б.Анхбаяр	Цагдаа
	Г.Мягмарцогт	Хэвлэл мэдээллийн ажилтан
	Ц.Цэнгэл	жолооч

3.Устгасан нохойг тусгай цэгт булж ариутгал халдваргүйжүүлэлт хийхийг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4.Золбин нохой устгалын ажлыг гүйцэтгэхэд ард иргэдийн аюулгүй байдлыг ханган, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн цагдаа (Б.Анхбаяр), гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг дүгнэж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Баасансүрэн) нарт даалгасугай.

5.Нохой устгалын зардал 2000000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг нягтлан бодогч (Л.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.


6.Золбин нохой устгалын ажлын тайланг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр танилцуулахыг ажлыг хэсэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

232501070



გაქვს დარღვევა